



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/75/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020

Аудитор:

Утас: 99359854

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Цахим хаяг:

Б.Байгал

Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	(Аудитын чиглэл)	
3.1.1	Илрүүлэлт:	
3.1.2	Эрсдэл:.....	
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	
3.2	(Аудитын чиглэл)	
3.2.1	Илрүүлэлт:	
3.2.2	Эрсдэл:.....	
3.2.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019-02-18 № 1-6/78

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД
СУМЫН ЗАХИРАГЧЫН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАЛ Т.ОТГОНБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Сайншанд сумын Захирагчийн ажлын албаний 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын албаний 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.


Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал:



- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэмэлт санхүүжилтын дансаар дамжуулан зарцуулсан 20370,0 мянган төгрөгийн шатахууны төлбөрийг нотлох баримт бүрдээгүй байхад олгосон байна. Түүнчлэн 2012 оны 1 сарын 20-ны өдөр Аймгийн ИТХ-аар баталсан "Дорноговь аймгийн Зам-үүд Сайншанд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих ахмад настан,ХБИ, оюутан сурагчдыг хөнгөлттэй нөхцөлөөр тээвэрлэх журам" журмыг үндэслэн олгож байгаа санхүүжилт зорилтод бүлэгтэй хүрч байгаа эсэхийг хянах ажил орхигдсон, гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөөгүй Дорноговь аймгийн ИТХ-аар баталсан журмыг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль 41,6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8.-д "Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Отгонбаяр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 12-ноос 18 –ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-тай хийсэн гэрээний үндсэн дээр Мөнгө Нөөц Баялаг Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мөнгө Нөөц Баялаг Аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 04/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын Захирагчийн ажлын алба нь Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах зорилготой. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Засаг дарга түүний тамгын газраас Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- АИТХ-ын тогтоол, Аймгийн Засаг даргын захирамж

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Сайншанд хотын Захирагчийн ажлын албаны 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/03 тоот тушаалаар Бодлогын баримт бичиг, журам баталсан байна. Уг баримт бичигт УСНББОУС-ийн зүйл заалт тодорхой бус, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан дансны заавар, журналын бичилтийг шаардлагатай хэмжээгээр тусгаагүй байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын Захирагчийн ажлын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 1 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлыг суурь болгож авсныг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны 67,906,3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 679,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь зардлын 1 хувиас бага эрсдэл нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	20,370.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	20,370.00	

2.9 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.9.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 20370,0 мянган төгрөгийн шатахууны төлбөрийг нотлох баримт бүрдээгүй байхад олгосон, олгож байгаа санхүүжилт зорилтод бүлэгтэй хүрч байгаа эсэхийг хянах ажил орхигдсон байна. Түүнчлэн 2012 оны 1 сарын 20-ний өдөр Аймгийн ИТХ-аар баталсан "Дорноговь аймгийн Зам-үүд Сайншанд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих ахмад настан,ХБИ, оюутан сурагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр тээвэрлэх журам" журмыг үндэслэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөөгүй Дорноговь аймгийн ИТХ-аар баталсан журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгож мөрдөх

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 75762,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлд, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 63,233,5 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь 155,8 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарч татан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын Захирагчийн ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Өмнөх оны аудитаар “Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 297 тоот тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдөөгүй нь “үнэлгээ, толилуулаг ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийн шаардлагыг хангахгүй байна.”

Дээрх зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд аудитын явцад дахин нягталсан болно. Үүнд: Сайншанд хотын Захирагчийн ажлын албаны 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/03 тоот тушаалаар Бодлогын баримт бичиг, журам баталсан байна. Уг баримт бичигт УСНББОУС-ийн зүйл заалт тодорхой бус, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар

батлагдсан дансны заавар, журналын бичилтийг шаардлагатай хэмжээгээр тусгаагүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ийн дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын алба нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Тайлант жилийн нэмэлт санхүүжилтийн дансаар бараа үйлчилгээний бусад зардал ангилалд 23575,0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Уг санхүүжилтийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага иргэнд түлш шатахууны хөнгөлөлт болгон өгсөн байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгүүлэх гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулсан тендерийн баримт байхгүй, худалдан авсан бараа бүтээгдэхүүнд хүчин төгөлдөр баримт хавсаргаагүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна 2012 оны 1 сарын 20-ний өдрийн Дорноговь аймгийн ИТХ-аар баталсан "Дорноговь аймгийн Зам-үүд Сайншанд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих ахмад настан,ХБИ, оюутан сурагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр тээвэрлэх журам" ТБОНӨХБАҮХАТ хуулийг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

1. Төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдана.

Зөвлөмж

Худалдан авалт бүрд Е баримт хавсаргах, худалдан авах ажиллагааны анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны Захирал Т.Отгонбаяр, нягтлан бодогч Ц.Адьяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 18-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ЛҮНДЭГМАА

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.БАЙГАЛ

Огноо:

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,619,600.00</u>	<u>8,737,100.00</u>
33	АВЛАГА	150,000.00	925,000.00
335	Бусад авлага	15,000.00	925,000.00
3351	Байгууллагаас авах авлага	15,000.00	925,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,469,600.00	7,812,100.00
354	Хангамжийн материал	7,469,600.00	7,812,100.00
35410	Бичиг хэргийн материал	922,100.00	1,154,600.00
35420	Аж ахуйн материал	6,547,500.00	6,657,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,879,033.70</u>	<u>3,179,534.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,879,033.70	3,179,534.02
392	Биет хөрөнгө	8,879,033.70	3,179,534.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,000,000.00	-8,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,546,100.00	11,546,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,145,086.72	-9,985,166.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,744,550.00	4,744,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,266,529.58	-3,125,949.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,498,633.70</u>	<u>11,916,634.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>315,000.00</u>	<u>405,863.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	315,000.00	405,863.00
413	Өглөг	315,000.00	405,863.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
4136	Бусад өглөг	00.00	40,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	40,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,183,633.70</u>	<u>11,510,771.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	16,183,633.70	11,510,771.02
512	Хуримтлагдсан үр дүн	16,183,633.70	11,510,771.02
51210	Өмнөх үеийн үр дүн	16,183,633.70	16,183,633.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,672,862.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,498,633.70</u>	<u>11,916,634.02</u>

4.2 АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	75,762,612.80	63,233,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,611,952.80	63,233,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,825,000.00	24,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,825,000.00	23,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,350,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,786,952.80	38,733,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,786,952.80	38,733,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	74,860,876.04	67,906,362.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,895,676.04	67,750,495.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,895,676.04	67,750,495.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,251,414.80	33,040,000.00
210101	Үндсэн цалин	42,251,414.80	33,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,900,289.00	4,160,863.00
210201	Тэтгэврийн даатгал	3,118,367.00	2,731,082.00
210202	Тэтгэмжийн даатгал	356,384.00	189,990.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	445,480.00	195,902.00
210204	Ажилгүйдлийн даатгал	89,095.00	95,116.00
210205	Эрүүл мэндийн даатгал	890,963.00	948,773.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,349,773.00	1,155,132.92
210401	Бичиг хэрэг	659,100.00	331,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	675,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,273.00	77,132.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,504,976.00	120,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,504,976.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,748,623.24	29,274,499.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,405,000.00	23,575,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,869,763.24	5,699,499.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,965,200.00	155,867.08
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	155,867.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	155,867.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	901,736.76	-4,672,862.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	901,736.76	-4,672,862.68

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	74,762,612.80	63,233,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,611,952.80	63,233,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,825,000.00	24,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,825,000.00	23,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,350,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,786,952.80	38,733,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,786,952.80	38,733,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	72,762,612.80	63,233,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,762,612.80	63,233,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,247,412.80	62,152,632.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,251,414.80	33,000,000.00
210101	Үндсэн цалин	42,251,414.80	33,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,735,289.00	3,960,000.00
210201	Тэтгэврийн даатгал	3,013,367.00	2,640,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	344,383.00	330,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	430,481.00	264,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	86,000.00	66,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	861,058.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,286,273.00	1,387,632.92
210401	Бичиг хэрэг	589,600.00	563,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	675,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,273.00	77,132.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	72,000.00
2105	Нормативт зардал	00.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,504,976.00	120,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,504,976.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,328,860.00	23,575,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,025,000.00	23,575,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,515,200.00	1,080,867.08
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,080,867.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,080,867.08

4.5 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	15,917,196.94	15,917,196.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-635,300.00	-635,300.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	15,281,896.94	15,281,896.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	901,736.76	901,736.76
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	16,183,633.70	16,183,633.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	16,183,633.70	16,183,633.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,672,862.68	-4,672,862.68
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	11,510,771.02	11,510,771.02

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,733,500.00	38,577,632.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,733,500.00	38,577,632.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,733,500.00	38,577,632.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,000,000.00	33,000,000.00
210101	Үндсэн цалин	33,000,000.00	33,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,960,000.00	3,960,000.00
210201	Тэтгэврийн даатгал	2,640,000.00	2,640,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	330,000.00	330,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	264,000.00	264,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	66,000.00	66,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	660,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,543,500.00	1,387,632.92
210401	Бичиг хэрэг	563,500.00	563,500.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	675,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,000.00	77,132.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	72,000.00
2105	Нормативт зардал	110,000.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,000.00	110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,000.00	120,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	120,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,733,500.00	38,733,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,733,500.00	38,733,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	38,733,500.00	38,733,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	05.00	05.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00